Сүхбаатар сумын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр засгаас гаргасан бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлж, ард иргэдийнхээ эрх ашгийг дээдэлж тэдний санал санаачилгад тулгуурлан, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж үндэсний баялаг бүтээгч иргэд бүхий байгаль орчинд ээлтэй, аялал жуулчлалыг дэмжсэн, хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, эрүүл мэнд, соёл боловсрол, эдийн засаг, дэд бүтцийг хөгжүүлсэн, хүний амьдрах ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгийг үр ашигтайгаар зарцуулж, аливаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн эцсийн үр дүнг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэж ажлын байраар хангах замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, шуурхай хүргэх.
- Сум орон нутгийнхаа өнгө үзэмж, иргэдийн боловсрол, эрүүл мэндэд анхаарч иргэдийнхээ ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Сүхбаатар сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сүхбаатар сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ашигладаггүй байна. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2009 оны 484 дугаар захирамжаар “Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” батлагдсан байна. Харин 2009 оноос хойш нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Сүхбаатар сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоодын хяналтын үр нөлөө дунд гэж үзлээ.

Сүхбаатар сумын сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэлээр хөтлөөгүй, санхүүгийн программаар санхүүгийн тайланг гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг зөрчсөн байна. Мөн Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг гаргахдаа сум хөгжлийн сангийн зээлийн мэдээллийн системийн мэдээлэлтэй тулган баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. дахь заалттай нийцэхгүй байна. Иймд Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын ажил гүйлгээг давхар бичилтийн аргаар хөтөлж, санхүүгийн тайланг программаар гаргах, зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй тулган баталгаажуулах зөвлөмж хүргүүлсэн.

Түүнчлэн Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын санхүүгийн программын хувьд мөнгөн гүйлгээн тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг алдаатай илэрхийлдэг, үндсэн хөрөнгө болон бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл болон ерөнхий журнал уялдаагүй, ерөнхий журнал дахь дебет, кредит ажил гүйлгээний дансны дугаар харагддаггүй, авлагын хугацаа, насжилтыг тооцоолдоггүй зэрэг алдаа, дутагдалтай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д заасан нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэдэг байна. Иймд санхүүгийн тайланг алдаагүй илэрхийлдэг, нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд тохиромжтой санхүүгийн программ хангамжтай болох зөвлөмж хүрүүлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 4,925.9 сая төгрөгийн 1.5 хувь буюу 73.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,276,707.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2,110,764.8 мянган төгрөг болж, 834,057.8 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| *Төрийн сангийн харилах* | *1,182,545.0* | *2,017,242.8* | *834,697.8* |
| *Арилжааны банк дахь харилцах* | *94,162.0* | *91,882.1* | *-2,279.9* |
| *Нэмэлт санхүүжилтийн харилцах* | *0.0* | *1,639.9* | *1,639.9* |
| **Дүн** | ***1,276,707.0*** | ***2,110,764.8*** | ***834,057.8*** |

*Эх сурвалж: Сүхбаатар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 2,017,242.8 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 91,882.1 мянган төгрөг арилжааны банкны дансанд, 1,639.9 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Харилцах дансны үлдэгдлийг байгууллагаар авч үзэхэд орон нутгийн хөгжлийн сан 1,299,424.9 мянга, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 471,288.9 мянга, сум хөгжүүлэх сан 132,960.2 мянга, орон нутгийн ерөнхий орлогын данс 113,559.8 мянга, Хайлааст голомт ОНӨААТҮГ 78,456.6 мянга, Эмийн эргэлийн сан 13,425.5 мянга, Эрүүл мэндийн төв 1,648.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 325,203.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 426,805.7 мянган төгрөг болж, 101,602.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| *Татаас, санхүүжилтийн авлага* | *684.66* | *0.00* | *-684.66* |
| *Ажиллагчидтай холбогдсон авлага* | *0.00* | *17,250.20* | *17,250.20* |
| *Зээлийн хүүгийн авлага* | *5,238.90* | *1,785.20* | *-3,453.70* |
| *Дансны авлага /ТӨҮГ/* | *52,360.24* | *74,505.38* | *22,145.13* |
| *Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/* | *4,188.81* | *901.81* | *-3,287.00* |
| *Байгууллагаас авах авлага* | *6,731.71* | *114,030.86* | *107,299.15* |
| *Хувь хүмүүсээс авах авлага* | *255,998.83* | *218,332.21* | *-37,666.62* |
| ***Дүн*** | ***325,203.15*** | ***426,805.66*** | ***101,602.51*** |

*Эх сурвалж: Сүхбаатар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын дансанд сум хөгжүүлэх сангийн гэрээний хугацаа дууссан болон эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлтөө хийгээгүй 15 зээлдэгчийн 98,082.9 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь тус сангийн мөнгөн хөрөнгийн эргэлтийг удаашруулах сөрөг үр дагавартай байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Тайлант оны эцэст Сүхбаатар сумын хүүхдийн цэцэрлэг 744.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагын үлдэгдэлтэй, Эрүүл мэндийн төв 1,914.4 мянган төгрөгийн НДШ-ийн авлагын үлдэгдэлтэй, Засаг даргын тамгын газар 1,994.4 мянган төгрөгийн түлш халаалтын авлагын үлдэгдэлтэй буюу нийт 4,653.0 мянган төгрөгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 7.7, 45.2 дахь заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.*
- *Сүхбаатар сумын ЗДТГ-аас 2017 оноос хэрэгжүүлж байгаа "Малжуулах хөтөлбөр"-ийн 950 эм хонийг 9 иргэнд 106,050.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд 66,735.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 дахь*

*заалтыг зөрчсөн тул залруулга хийлгэж, санхүүгийн тайланд авлагаар тусгуулсан.*

- *Сум хөгжүүлэх сангийн хувьд гэрээний хугацаа дууссан буюу 3 жил болсон боловч төлөгдөөгүй үндсэн зээлийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд хүү тооцож авлагаар бүртгээгүй, мөн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлөлт хийгдээгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс алданги бодож авлагаар бүртгээгүй байна. Энэ нь "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.6.1, 1.7 дахь заалтыг зөрчсөн тул зөвлөмж хүргүүлэв.*

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 677,478.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 843,979.2 мянган төгрөг болж, 166,501.2 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалттай материал | 0.00 | 80.15 | 80.15 |
| Эм боох материал | 17,348.79 | 14,901.80 | -2,446.99 |
| Бичиг хэргийн материал | 219.14 | 1,152.90 | 933.76 |
| Аж ахуйн материал | 36,150.54 | 46,909.17 | 10,758.63 |
| Сэлбэг хэрэгсэл | 453.65 | 453.65 | 0.00 |
| Түлш, шатах тослох материал | 11,309.69 | 15,245.89 | 3,936.20 |
| Хүнсний материал | 0.00 | 480.73 | 480.73 |
| Бусад хангамжийн материал | 611,996.23 | 744,754.90 | 132,758.67 |
| Биологийн хөрөнгө | 0.00 | 20,000.00 | 20,000.00 |
| **Дүн** | **677,478.04** | **843,979.19** | **166,501.14** |

*Эх сурвалж: Сүхбаатар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд бараа материал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 566,230.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 246,411.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, зарцуулсан 640,517.3 мянган төгрөгөөр хасагдсан байна. Сүхбаатар сумын төвд 2017 оноос баригдаж эхэлсэн 1,500,064.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй замын ажлын 2019 оны эцсийн байдлаар гаргасан 607,078.5 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлээр сумын ЗДТГ-ын бусад хангамжийн материалд бүртгэсэн байна. Энэ нь бараа материалын нийт үлдэгдлийн 71.9 хувийг эзэлж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Малын чанарыг сайжруулах зорилгоор Үзэмчин, Баяндэлгэрийн улаан үүлдрийн өсвөр хээлтүүлэгч бойжуулж, бог малын цөм сүрэг бий болгох ажил үйлчилгээний гэрээний дагуу ОНХС-аас 20,000.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Үзэмчин үүлдрийн 70 хурган хуц, Баяндэлгэрийн улаан үүлдрийн 30 ишгэн ухныг сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 дахь заалтыг зөрчсөн тул ЗДТГ-ын санхүүгийн тайланд залруулга хийлгэж, эргэлтийн хөрөнгөнд тусгуулсан.*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,678,095.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7,371,226.3 мянган төгрөг болж, 1,693,130.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга, байгууламж, орон сууц | 4,276,952.00 | 5,503,450.41 | 1,226,498.41 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 61,123.03 | 276,205.85 | 215,082.82 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 464,237.94 | 499,083.12 | 34,845.18 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,903.73 | 111,268.57 | 29,364.84 |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 186,577.59 | 186,577.59 | 0.00 |
| Бусад үндсэн хөрөнгө | 460,266.41 | 642,543.55 | 182,277.14 |
| Ном | 40,169.89 | 45,231.96 | 5,062.07 |
| Програм хангамж | 20,835.20 | 21,179.20 | 344.00 |
| Бусад биет бус хөрөнгө | 86,030.00 | 85,686.00 | -344.00 |
| Дүн | **5,678,095.79** | **7,371,226.26** | **1,693,130.47** |

*Эх сурвалж: Сүхбаатар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 41,167.7 мянга, балансаас балансstates шилжүүлэн авсан 353,783.1 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,987,135.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 319,967.1 мянга, акталсан 89,285.0 мянга төгрөгөөр хасагдсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө ЗДТГ-т 208 ширхэг, Хүүхдийн цэцэрлэгт 46 ширхэг, ЕБС-д 159 ширхэг, ЭМТ-д 139 ширхэг, нийт 552 ширхэг үлдэгдэл өртөггүй хөрөнгө тус байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж хүргүүлэв.*
- *Нэг бүр нь 58.5 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг утлагын аппаратыг 2018 онд орлого авахдаа тоо хэмжээ, үнийн дүнг зөрүүлж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн тул бүртгэлийн алдааг залруулах зөвлөмж хүргүүлэв.*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 899,021.9 мянга, эцсийн үлдэгдэл 1,513,280.0 мянган төгрөг болж, 614,258.2 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5. Өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 14,914.83 | 22,312.27 | 7,397.44 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 169.81 | 64,370.10 | 64,200.29 |
| Байгууллагад төлөх өглөг | 107,315.51 | 127,983.73 | 20,668.22 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 3,187.52 | 1,301.30 | -1,886.21 |
| Татварын өглөг /ТӨҮГ/ | 5,655.31 | 10,439.31 | 4,784.00 |
| НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 562.04 | 511.59 | -50.46 |
| Бусад урьдчилж орсон орлого | 767,216.85 | 1,287,238.99 | 520,022.14 |
| Дүн | **899,021.85** | **1,514,157.28** | **615,135.43** |

*Эх сурвалж: Сүхбаатар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өр төлбөр дансны үлдэгдэл өсөхөд ЕБС-ийн шинээр баригдсан спорт заалны халаалтын өглөг 56,051.9 мянга, Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын үнэ төлбөргүй хүлээн

авсан үндсэн хөрөнгийг орлогын аргаар бүртгэсэнтэй холбоотойгоор урьдчилж орлого дансны үлдэгдэл 520,022.1 мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Сүхбаатар сумын ИТХ, ЗДТГ, Цэцэрлэг, ЭМТ болон Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын татварын өр төлбөрийн үлдэгдлийг татварын тодорхойлолттой тулган шалгахад зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтыг зөрчсөн тул зөвлөмж хүргүүлсэн.*
- *ЕБС нь 56,051.9 мянган төгрөгийн түлш халаалтын өр төлбөр, 312.3 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр, байгууллагад төлөх 54.0 мянган төгрөгийн, нийт 56,418.1 мянган төгрөгийн өр төлбөртэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтыг зөрчсөн тул зөвлөмж хүргүүлсэн.*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,058,462.2 мянга, эцсийн үлдэгдэл 9,238,618.7 мянган төгрөг болж, 2,180,156.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл /мянган төгрөг/*

| *Үзүүлэлт* | *Эхний үлдэгдэл* | *Эцсийн үлдэгдэл* | *Өсөлт (+), Бууралт (-)* |
|---|---|---|---|
| ***Засгийн газрын хувь оролцоо*** | ***7,058,462.17*** | ***9,238,618.64*** | ***2,180,156.48*** |
| *Засгийн газрын оруулсан капитал* | *2,503,116.66* | *2,503,116.66* | *0.00* |
| ***Хуримтлагдсан үр дүн*** | ***3,322,175.94*** | ***5,502,332.41*** | ***2,180,156.48*** |
| *Өмнөх үеийн үр дүн* | *1,460,274.27* | *3,322,175.94* | *1,861,901.66* |
| *Тайлант үеийн үр дүн* | *1,861,901.66* | *2,180,156.48* | *318,254.81* |
| *Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү* | *1,233,169.57* | *1,233,169.57* | *0.00* |

*Эх сурвалж: Сүхбаатар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9,246,083.6 мянган төгрөг болж 2,180,156.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Орлогын албан татвар 87,519.8 мянга, хөрөнгийн албан татвар 150,748.5 мянга, бусад татвар, төлбөр, хураамж 102,731.4 мянга, татварын бус орлого 3,341,899.8 мянга, улсын төсвийн санхүүжилт 5,065,654.5 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 415,113.7 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилт 674,867.7 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 83,535.4 мянга, нийт 9,922,070.8 мянган төгрөгийн орлого орсон байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Сум хөгжүүлэх сангийн хүүгийн орлогыг орлого, үр дүнгийн тайланд илэрхийлээгүй, мөнгөн гүйлгээний тайланд хүүгийн орлогыг зээлийн эргэн төлөлтийн дүнтэй нэгтгэн тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5 дэх заалтыг зөрчсөн тул зөвлөмж хүргүүлсэн.*

### 3.5.11 Зардлын данс

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,736,900.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 220,327.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 283,326.0 мянга, хангамж, бараа материалын зардал 71,013.7 мянга, нормативд зардал 172,508.3 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 18,602.9 мянга, томилолт, зочны

зардал 5,614.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 351,019.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,138,559.5 мянга, бусад урсгал шилжүүлэг 101,905.0 мянга, үйл ажиллагааны бус зардалд 3,642,137.2 мянга, нийт 7,741,914.3 мянган төгрөгийн зардал тайлагнасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Ерөнхий боловсролын сургууль хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 хүний цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос 574.8 мянган төгрөгийг илүү суутгасан. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.*
- *Ерөнхий боловсролын сургууль нийт 7 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 5,278.9 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, 20.2.6, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2 дахь заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.*
- *Хайлааст голомт ОНӨААТҮГ тайлант онд 1,115.1 мянган төгрөгийн НӨАТ ногдох 12,266.5 мянган төгрөгийн тээврийн хөлсийг Шаргын хурд ХХК-нд шилжүүлсэн боловч НӨАТ-ын баримт татварын цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2 дахь заалтыг зөрчсөн тул зөвлөмж хүргүүлсэн.*
- *Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний НӨАТ-ын баримтыг сумын ЗДТГ-ын регистрээр бус тухайн хөрөнгө материалыг хүлээн авсан төсвийн бусад байгууллагын регистрээр татварын цахим системд бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаар шивүүлсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.1, 17.3.2 дахь заалтыг зөрчсөн тул зөвлөмж хүргүүлсэн.*

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

## Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сүхбаатар сумын ИТХ-ын “2021 оны орон нутгийн төсөв батлах тухай” 2020 оны 12 сарын 18-ны өдрийн А/07 дугаар тогтоолд орон нутгийн нийт төсвийн орлогыг 6,616,506.9 мянган төгрөгөөр баталжээ. Сүхбаатар сумын ИТХ-ын “2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 2021 оны 8 сарын 05-ны өдрийн А/53 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн нийт орлогыг 8,102,764.9 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсөв тодотгосон тогтоолд заасаар Сүхбаатар сумын Засаг дарга тайлант онд 350,100.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 360,449.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 103.0 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт №7. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| *Үйл ажиллагааны орлого* | *22,000.00* | *22,582.56* | *582.56* | *2.6* |
| *Хөрөнгийн орлого* | *30,000.00* | *28,509.67* | *-1,490.33* | *-5.0* |
| *Хөрөнгө борлуулсны орлого* | *7,500.00* | *8,519.74* | *1,019.74* | *13.6* |
| *Шууд бус орлого* | *22,200.00* | *27,907.89* | *5,707.89* | *25.7* |
| *Бууны албан татвар* | *3,500.00* | *2,801.00* | *-699.00* | *-20.0* |
| *Малд ногдуулах албан татвар* | *154,400.00* | *147,947.50* | *-6,452.50* | *-4.2* |
| *Улсын тэмдэгтийн хураамж* | *2,500.00* | *1,169.63* | *-1,330.37* | *-53.2* |
| *Түгээмэл тархацтай ашигт малтмал* | *25,000.00* | *2,125.00* | *-22,875.00* | *-91.5* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| *ашигласны төлбөр* | | | | |
| *Хог хаягдлын үйлчилгээний хураамж* | *4,000.00* | *4,300.00* | *300.00* | *7.5* |
| *Газрын төлбөр* | *25,000.00* | *57,847.67* | *32,847.67* | *131.4* |
| *Ус, рашааны нөөц ашигласны төлбөр* | *2,000.00* | *4,362.05* | *2,362.05* | *118.1* |
| *Агнуурын нөөц ашигласны төлбөр* | *5,000.00* | *0.00* | *-5,000.00* | *-100.0* |
| *Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр* | *2,000.00* | *7,927.00* | *5,927.00* | *296.4* |
| *Бусад татвар* | *25,000.00* | *25,000.00* | *0.00* | *0.0* |
| *Торгуулийн орлого* | *20,000.00* | *19,450.00* | *-550.00* | *-2.8* |
| ***Нийт дүн*** | ***350,100.00*** | ***360,449.71*** | ***10,349.71*** | ***3.0*** |

Агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 5,000.0 мянган төгрөгөөр тасарсан нь ковид цар тахлын улмаас хөдөөгийн багуудад эргүүл, хяналт шалгалтын ажил хийгээгүйгээс шалтгаалсан байна. Түгээмэл тархацтай ашиг малтмал ашигласны төлбөрийн орлого 22,875.0 мянган төгрөгөөр тасарсан нь ковид цар тахлын улмаас тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын сул зогсолтоос шалтгаалсан байна.

## Төсвийн төлөвлөлт

Тус сумын Засаг даргын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,616,506.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 6,616,506.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Сүхбаатар сумын Засаг даргын хүргүүлсэн төсвийн төсөлд тусгагдсан орлого, зарлагын дүнгээр Сүхбаатар сумын ИТХ баталсан байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Сүхбаатар сумын Засаг даргын хэрэгжүүлэх 24 хөтөлбөрт зориулан 8,262,606.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,418,787.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 4,723,819.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 120,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 106,520.6 мянга, БЭМС-ийн санхүүжилт 1,140,999.0 мянга, орон нутгийн төсвөөс 1,019,820.9 мянга, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,557,936.1 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18,459.3 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 3,505,098.0 мянга, нийт 7,348,833.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,573,201.2 мянган төгрөг буюу 79.6 хувьтай байгаа нь орон нутгийн хөгжлийн сангийн зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 1,323,127.5 мянган төгрөгөөр бага, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 193,370.2 мянган төгрөгөөр бага, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөгдөх зээлийн зардалд 120,000.0 мянган төгрөг төлөвлөсөн боловч тайлант онд зээл олгоогүйтэй холбоотой байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн этгээдээс авсан хандив, тусламж 30,040.0 мянга, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 55,966.1 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 330,007.7 мянга, нийт 416,013.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил 93,331.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 160.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,714.8 мянга, хангамж, бараа материалын зардал 18,036.6 мянга, нормативд зардал 555.4 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 13,148.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 182,496.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 24,540.1 мянга, урсгал шилжүүлэг 78,391.1 мянга, нийт 414,373.8 мянган төгрөгийг зарцуулж, 1,639.9 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сүхбаатар сумын Засаг даргын шилэн дансны мэдээллийг шалгахад төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг мэдээлээгүй, 47 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

Сүхбаатар сумын Засаг даргын харьяа байгууллагууд шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлсэн эсэхийг шалгахад ИТХ 6 мэдээлэл, ЗДТГ 15 мэдээлэл, ЕБС 4 мэдээлэл, Цэцэрлэг 17 мэдээлэл, Хайлааст голомт 33 мэдээлэл, ЭМТ 88 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. ИТХ, ЗДТГ, ЕБС болон Цэцэрлэг санхүүжилтийг тухай бүр, жилийн дүн нь 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг өссөн дүнгээр сар бүр мэдээлээгүй байна. Мөн орон нутгийн хөгжлийн сан, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангууд бие даасан шилэн дансны хаяггүй, тухайн сангуудын санхүүгийн тайлан болон холбогдох бусад мэдээлэл бүрэн бус мэдээлэгдсэн байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сүхбаатар сумын Засаг даргад 183,900.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт №8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Албан шаардлага | 1 | 183,900.0 | 1 | 183,900.0 | | | 100 |
| Зөвлөмж | 2 | 0.0 | 2 | 0.0 | | | 100 |
| **Нийт** | **3** | **183,900.0** | **3** | **183,900.0** | | | **100** |

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 тусгай сангийн нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүврээр хамрагдсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 6 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, худалдан авах ажиллагааны дотоод хяналт, шилэн данстай холбоотой зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хүргүүллээ. Төвлөрүүлэн захирагчид өгсөн 6 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 964,867.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 86,735.0 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 5,227.8 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,278.9 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 867,625.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 25 зөвлөмжийг хүргүүллээ.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар биологийн хөрөнгө болох мал амьтадыг бодит үнэ цэнийн аргаар санхүүгийн тайланд толилуулсан эсэх; орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийг дуусаж, ашиглагч байгууллагын данс бүртгэлд шилжүүлэх хүртэл хугацаанд тухайн сангуудын санхүүгийн тайланд бүртгэсэн эсэх; тус сумын ЗДТГ-ын бусад хангамжийн материалд 607,078.5 мянган төгрөгийн бүртгэлтэй байгаа замын ажлын гүйцэтгэлийг тухайн замын ажил дууссаны дараа санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнасан эсэх асуудлыг авч үзэхээр төлөвлөж байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Орон нутгийн ерөнхий орлогын нягтлан бодох бүртгэл, дотоод хяналттай холбоотой асуудал

3.1.1 *Илрүүлэлт:* Орон нутгийн ерөнхий орлогын хувьд нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэл, журнал хөтлөлгүйгээр, Э-Тайланд холбогдох тоон утгуудыг шивж санхүүгийн тайланг гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.2, 14.4, Төсвийн тухай хуулийн 6.3.2, 37.1.7 заалттай нийцэхгүй байна.

3.1.2 *Эрсдэл:* Нягтлан бодох бүртгэлийг НББ-ийн тухай хуульд заасан дараалаар хөтлөөгүйн улмаас санхүүгийн тайланг алдаатай илэрхийлэх.

3.1.3 *Өгсөн зөвлөмж:* Орон нутгийн ерөнхий орлогын орлого, зарлагын ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй бүртгэлээр хөтөлж, санхүүгийн тайланг программаар гаргах.

3.1.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар*: Хүлээн зөвшөөрсөн:

### 3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлын нягтлан бодох бүртгэл, дотоод хяналттай холбоотой асуудал

3.2.1 *Илрүүлэлт:* Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй, сумын санхүүгийн албаны дарга арга зүйн удирдлагаар хангаж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

3.2.2 *Эрсдэл:* Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

3.2.3 *Өгсөн зөвлөмж:* Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

3.2.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар*: Хүлээн зөвшөөрсөн:

**3.3 Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн нягтлан бодох бүртгэл, дотоод хяналттай холбоотой асуудал**

3.3.1 *Илрүүлэлт:* Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хийгдсэн зураг төсвийг зам, барилгын ажил дуусах хүртэлх хугацаанд тухайн төсөл арга хэмжээ бүрээр нээсэн дуусаагүй үйлдвэрлэл дэд дансанд бүртгэлгүйгээр тайлант үеийн зардлаар тайлагнасан, сумын санхүүгийн албаны дарга арга зүйн удирдлагаар хангаж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 14.4.2 заалттай нийцэхгүй байна.

3.3.2 *Эрсдэл:* Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг төсвийн зардлыг барилга, байгууламжийн анхны өртөгт шингээлгүй, зардалд илэрхийлэх эрсдэлтэй байна.

3.3.3 *Өгсөн зөвлөмж:* Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хийгдсэн зураг төсвийг зам, барилгын ажил дуусах хүртэлх хугацаанд тухайн төсөл арга хэмжээ бүрээр нээсэн дуусаагүй үйлдвэрлэл дэд дансанд бүртгэж байх.

3.3.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар*: Хүлээн зөвшөөрсөн:

**3.4 Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын худалдан авалтад тавих дотоод хяналттай холбоотой асуудал**

3.4.1 *Илрүүлэлт:* Хайлааст голомт ОНӨААТҮГ тендер сонгон шалгаруулалтгүйгээр нүүрс худалдан авч байгаа зөрчилд сумын Засаг даргаас дотоод хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

3.4.2 *Эрсдэл:* Харьяа байгууллагын худалдан авах ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй нь тендер сонгон шалгаруулалтгүй худалдан авалт хийгдэх эрсдэлтэй байна.

3.4.3 *Өгсөн зөвлөмж:* Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт нь жилийн дүнгээр 20 сая төгрөгөөс дээш тохиолдолд тендер сонгон шалгаруулалт зарлуулах, хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

3.4.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар*: Хүлээн зөвшөөрсөн:

**3.5 Сангуудын шилэн данстай холбоотой асуудал**

3.5.1 *Илрүүлэлт:* Сумын орон нутгийн хөгжлийн сан, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон сум хөгжүүлэх сангууд шилэн дансны нэгдсэн цахим системд тусгай хаяг нээлгээгүйн улмаас сангуудын санхүүгийн тайлан болон холбогдох бусад мэдээлэл бүрэн бус мэдээлэгдсэн, сумын санхүүгийн албаны дарга арга зүйн удирдлагаар хангаж ажиллаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

3.5.2 *Эрсдэл:* Дээрх сангуудад шилэн дансны бие даасан хаяг нээлгээгүй нь тухайн сангуудын санхүүгийн тайлан болон холбогдох бусад мэдээлэл шилэн нэгдсэн цахим хуудаст бүрэн бус мэдээлэгдэх эрсдэлтэй байна.

3.5.3 *Өгсөн зөвлөмж:* Сумын орон нутгийн хөгжлийн сан, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон сум хөгжүүлэх сангуудад шилэн дансны нэгдсэн цахим системд бие даасан хаяг нээлгэх, хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

3.5.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар*: Хүлээн зөвшөөрсөн:

**3.6 Сүхбаатар сумын Засаг даргын шилэн данстай холбоотой асуудал**

3.6.1 *Илрүүлэлт:* Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд Сүхбаатар сумын Засаг даргын төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг мэдээлээгүй, 47 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

3.6.2 *Эрсдэл:* Шилэн дансны мэдээлэл иргэд, олон нийтэд мэдээлэл бүрэн бус, цаг хугацаандаа хүрэхгүй байх эрсдэлтэй байна.

3.6.3 *Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

3.6.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар*: Хүлээн зөвшөөрсөн:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

## 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| **Огноо:** 2022.03.25 | **Аудитын нэр:** | **Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит** | **Аудитын код:** СБА-2022/08/НА-СТА-ТТ3 |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | **Сүхбаатар сумын Засаг дарга** | | **Сая төгрөгөөр** |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Орон нутгийн ерөнхий орлогын хувьд нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэл, журнал хөтлөлгүйгээр, Э-Тайланд холбогдох тоон утгуудыг шивж санхүүгийн тайланг гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.2, 14.4, Төсвийн тухай хуулийн 6.3.2, 37.1.7 заалттай нийцэхгүй байна. | 0 | Зөвлөмж | Сумын Засаг дарга Санхүүгийн албаны дарга | Б.Батхүрэл Т.Цэнгэлчимэг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй, сумын санхүүгийн албаны дарга арга зүйн удирдлагаар хангаж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна. | 0 | Зөвлөмж | Сумын Засаг дарга Санхүүгийн албаны дарга | Б.Батхүрэл Т.Цэнгэлчимэг |
| 3 | Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хийгдсэн зураг төсвийг зам, барилгын ажил дуусах хүртэлх хугацаанд тухайн төсөл арга хэмжээ бүрээр нээсэн дуусаагүй үйлдвэрлэл дэд дансанд бүртгэлгүйгээр тайлант үеийн зардлаар тайлагнасан, сумын санхүүгийн албаны дарга арга зүйн удирдлагаар хангаж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 14.4.2 заалттай нийцэхгүй байна. | 0 | Зөвлөмж | Сумын Засаг дарга Санхүүгийн албаны дарга | Б.Батхүрэл Т.Цэнгэлчимэг |
| 4 | Хайлааст голомт ОНӨААТҮГ тендер сонгон шалгаруулалтгүйгээр нүүрс худалдан авч байгаа зөрчилд сумын Засаг даргаас дотоод хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1.1 дэх заалттай нийцэхгүй байна. | 0 | Зөвлөмж | Сумын Засаг дарга Санхүүгийн албаны дарга | Б.Батхүрэл Т.Цэнгэлчимэг |
| 5 | Сумын орон нутгийн хөгжлийн сан, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон сум хөгжүүлэх сангууд шилэн дансны нэгдсэн цахим системд тусгай хаяг нээлгээгүйн улмаас сангуудын санхүүгийн тайлан болон холбогдох бусад мэдээлэл бүрэн бус мэдээлэгдсэн, сумын санхүүгийн албаны дарга арга зүйн удирдлагаар хангаж ажиллаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 дэх заалттай нийцэхгүй байна. | 0 | Зөвлөмж | Сумын Засаг дарга Санхүүгийн албаны дарга | Б.Батхүрэл Т.Цэнгэлчимэг |
| 6 | Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд Сүхбаатар сумын Засаг даргын төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг мэдээлээгүй, 47 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна. | 0 | Зөвлөмж | Сумын Засаг дарга Санхүүгийн албаны дарга | Б.Батхүрэл Т.Цэнгэлчимэг |
| | **Дүн** | 0 | | | |